

Сөёл урлагийн газар



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 07 дугаар
сарын 09-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай

Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор улсын хэмжээнд эрчимжүүлэх, бүх түвшинд хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг мөрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч байна:

1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1. Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд.

1.1.1. Хүүхдийг аливаа осол, гэмтлээс сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, аюулгүй ажиллагааны холбогдох стандарт шаардлагыг мөрдүүлэх, хүүхдийн тоглоомын байгууламж болон гадна тоглоомын талбайн техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангах, засвар үйлчилгээний байдалд хяналт, шалгалтыг улирал тутамд хийх;

1.1.2. Хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн мөлжлөгийн төрлөөр Монгол Улсын нэгдэн орсон олон Улсын гэрээ конвенц болон хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулах;

1.1.3. Цэцэрлэг, сургууль, хүүхдийн байгууллагын байрнаас 100 метр зайд архи, тамхи, согтууруулах ундаа худалдахгүй, үйлчлэхгүй байх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах, хаах хүртэл арга хэмжээ авах;

1.1.4. Стандартын улсын үзлэг зохион байгуулж, шинэчлэх шаардлагатай стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэх ажлыг зохион байгуулах, хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангах асуудлаар салбар дундын үзлэг, шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулах;

1.1.5. Улсын баяр наадмын болон бүсийн хурдан морины уралдааны үеэр хүүхэд, иргэдийн аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хурдан морь унаач хүүхдийн хууль тогтоомжоор заасан насны хязгаарыг баримталж, бүртгэлийг зохион байгуулах, хамгаалалтын хувцас хэрэгслийг бүрэн хэрэглүүлэхэд хяналт тавих.

1.2.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуул зөвлөлийн гишүүд, холбогдох мэргэжлийн /хууль сахиулах, онцгой байдлыг мэргэжлийн хяналтын, хүүхдийн болон бусад/ байгууллагын дарга нарт:

1.2.1.Гэмт хэрэг, үер усны болон болзошгүй аюул, эрсдэл, ослын габуй шалтгаан нөхцөлийг тогтоож, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдэд анхааруулах, сануулах, мэдээлэл ажлыг тогтмол өндөр хэмжээнд зохион байгуулах;

1.2.2.Иргэдийн тэр дундаа насанд хүрээгүй хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийг хангах, гэмт хэрэг, осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажилд иргэн болон аж ахуйн нэгж байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах;

1.2.3.Нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, албан байгууллагын мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтын ажлыг дурдсан хугацаанд тогтсон өдөрт зохион байгуулж, гарсан зөрчил дутагдлыг үнэн зөв мэдээлэх, арилгуулах чиглэлээр хугацаатай үүрэг, даалгаврыг өгч, хэрэгжилтэнд нэг хяналт тавих, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шаардлагатай арга хэмжээ авах.

1.3.Нутгийн захиргааны болон бусад албан байгууллага, аж ахуйн нэгж иргэдэд:

1.3.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага бүр өмчийн харьяалал үл хамааран орчны тохижилт, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах, стандартын шаардлагыг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, насанд хүрээгүй хүүхэд зэрэг онцгой анхаарал халамж шаардагч иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангасан байх;

1.3.2.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, амрахаар эрхийг хангах чиглэлээр хууль тогтоомж, дүрэм журмыг биелүүлэх;

1.3.3.Гэмт хэрэг, зөрчил дутагдал, осол эндэгдэл гарсан тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагад яаралтай мэдээлэх, зөрчлийг арилгуулах чиглэлээр харилцан шаардлага тавих;

1.3.4.Хүүхдийн сурч боловсрох, хөгжих, тоглож наадах орчин нөхцлийн аюулгүй байдалд онцгой анхаарч, орон байр, сургууль цэцэрлэг, нийтийн эзэмшлийн зам талбайн стандартыг хангуулах ажлыг зохион байгуулах;

1.3.5.Мэргэжлийн байгууллагын тавьсан шаардлага, сануулга, мэдээллийг ойр орчны иргэд, хүүхэд, залуучуудад уламжлах, мэдээлэх, сэргийлэх.

1.4.Хэвлэл мэдээллийн байгууллага, албан тушаалтанд:

1.4.1.Иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, хэв журмын зөрчил, болзошгүй аюул, осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдийг үнэн зөв мэдээллээр хангахыг уриалах;

2.“Бидний эрүүл мэнд, аюулгүй байдал” нэг өдрийг сар бүрийн 09-ний өдөрт товлон өмчийн төрөл үл хамааран, нутгийн захиргааны болон бусад бүх